



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2022 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 341

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 165,000,000.00 (нэг зуун жаран таван сая) төгрөгийн балансын үнэ, 71,376,766.78 (далан нэгэн сая гурван зуун далан зургаан мянга долоон зуун жаран зургаан төгрөг далан найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий тээврийн хэрэгслийг хавсралтад заасны дагуу "Цемент шохой" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. "Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа, "Цемент шохой" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Л.Наранбаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн
 дугаар тогтоолын хавсралт

"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК-ийн балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (өртөг)
1	Тоёота Ланд круйзер-200, 00-38 УББ улсын дугаар, JTMHV05J604169731 арлын дугаар	2017	1	ш	165,000,000.00	71,376,766.78	93,623,233.22
Нийт дүн					(нэг зуун жаран таван сая)	(далан нэгэн сая гурван зуун далан зургаан мянга долоон зуун жаран зургаан төгрөг далан найман мөнгө)	(ерэн гурван сая зургаан зуун хорин гурван мянга хоёр зуун гучин гурван төгрөг хорин хоёр мөнгө)